

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага.....	14
3.5.4 Урьдчилгаа	15
3.5.6 Бараа материал	15
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.8 Өр төлбөр	16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	16
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.7 Шилэн дансны мэдээлэл	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	19
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	20
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	21
4. Менежментийн захидал.....	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДАШДЭМБЭРЭЛ
ТАНАА

2021.03.25 № 01/997
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын тайлант онд дэвшүүлсэн 55 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилтийг 88.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,295,207.9	2,353,721.1
31	Мөнгөн хөрөнгө	30,822.8	39,473.4
33	Авлага	2,016,858.9	910,330.9
34	Урьдчилгаа	0.0	9,019.2
35	Бараа материал	1,247,526.2	1,394,897.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	35,158,532.6	45,756,024.9
39	Үндсэн хөрөнгө	35,158,532.6	45,756,024.9
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	29,857,844.4	39,896,711.3
39300	Биет бус хөрөнгө	5,300,688.2	5,859,313.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,453,740.5	48,109,746.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,438.6	12,632.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,438.6	12,632.7
41300	Өглөг	6,438.6	12,632.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	38,447,302.0	48,097,113.3
51	Засгийн газрын хувь оролцоо	38,447,302.0	48,097,113.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,418,413.3	14,585,763.3
51200	Хуримтлагдсан үр дүн	17,679,261.9	27,379,321.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,349,626.7	6,132,028.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,453,740.5	48,109,746.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	36,157,162.9	121,824,551.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,049,789.1	15,864,495.1
120	Нийтлэг татварын бус орлого	6,049,789.1	15,864,495.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,107,373.8	105,960,056.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	35,346,533.4	111,590,539.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,346,533.4	111,590,539.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,950,415.7	32,175,581.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,171,633.7	20,165,055.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,106,284.9	2,498,861.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,724,955.4	1,914,405.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,597,760.2	1,047,105.2
2105	Норматив зардал	811,906.2	664,292.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	278,658.3	112,853.7
2107	Томилолт, зочны зардал	279,563.5	38,524.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,306,006.4	2,351,458.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,673,647.0	3,383,023.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,396,117.8	79,414,957.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	810,629.5	10,234,012.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,539.0	39,155.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	218,974.2	807,945.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	598,194.2	9,465,222.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	33,547,450.8	109,223,680.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,182,425.4	1,683,846.1
120	Нийтлэг татварын бус орлого	3,182,425.4	1,683,846.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,365,025.5	107,539,834.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,281,485.3	109,034,706.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,281,485.3	109,034,706.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,326,284.2	29,130,176.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,939,600.9	19,838,976.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,068,306.7	2,523,426.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,745,399.4	1,930,472.0
2104	Хангамж, бараа материалын зардал	917,985.9	875,329.0
2105	Нормативт зардал	813,970.9	673,656.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	347,608.5	152,220.8
2107	Томилолт, зочны зардал	282,526.8	38,324.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,621,617.2	2,634,746.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	589,268.0	463,022.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,955,201.1	79,904,530.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	265,965.6	188,974.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	276,986.4	177,006.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	276,986.4	177,006.4
2200	Дотоод эх үүсвэрээр	276,986.4	177,006.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-276,986.4	-177,006.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-5,672.5	-3,317.2
14	Бусад эх үүсвэр	789.2	151.5
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	6,461.6	3,468.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-16,693.3	8,650.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,516.1	30,822.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,822.8	39,473.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,940,954.1	-	37,940,954.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-89,721.4	-	-89,721.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,851,232.6	-	37,851,232.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,124.9	-	-2,124.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	598,194.2	-	598,194.2
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,447,302.0	-	38,447,302.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	234,836.9	-	234,836.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,682,138.9	-	38,682,138.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-48,848.1	-	-48,848.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-1,400.0	-	-1,400.0
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	9,465,222.5	-	9,465,222.5
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	48,097,113.3	-	48,097,113.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,768,550,900.00	27,477,997,750.66	1,290,553,149.34	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,768,550,900.00	27,477,997,750.66	1,290,553,149.34	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,134,076,900.00	26,926,505,764.51	1,207,571,135.49	95.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,739,402,400.00	19,648,192,810.77	91,209,589.23	99.5
210101	Үндсэн цалин	14,101,395,800.00	14,336,880,031.94	-235,484,231.94	101.7
210102	Нэмэгдэл	4,625,612,400.00	4,293,659,450.95	331,952,949.05	92.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,012,394,200.00	978,132,299.68	34,261,900.32	96.6
210104	Урамшуулал	0.00	39,521,028.20	-39,521,028.20	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,566,972,800.00	2,501,637,170.33	65,335,629.67	97.5
210201	Тэтгэврийн даатгал	1,820,597,300.00	1,853,551,550.94	-32,954,250.94	101.8
210202	Тэтгэмжийн даатгал	186,593,500.00	175,458,954.16	11,134,545.84	94.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	149,275,100.00	127,683,926.19	21,591,173.81	85.5
210204	Ажилгүйдлийн даатгал	37,318,700.00	31,121,487.70	6,197,212.30	83.4
210205	Эрүүл мэндийн даатгал	373,188,200.00	313,821,251.34	59,366,948.66	84.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,139,316,300.00	1,917,072,796.60	222,243,503.40	89.6
210301	Гэрэл, цахилгаан	363,860,400.00	317,382,676.37	46,477,723.63	87.2
210302	Түлш, халаалт	997,462,100.00	929,493,352.80	67,968,747.20	93.2
210303	Цэвэр, бохир ус	185,209,600.00	139,201,655.43	46,007,944.57	75.2
210304	Байрны түрээс	592,784,200.00	530,995,112.00	61,789,088.00	89.6
2104	Хангамж, бараа материалын зардал	642,493,400.00	568,703,670.44	73,789,729.56	88.5
210401	Бичиг хэрэг	135,041,000.00	128,633,870.24	6,407,129.76	95.3
210402	Тээвэр, шатахуун	152,183,900.00	128,528,482.90	23,655,417.10	84.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,172,200.00	110,628,609.94	26,543,590.06	80.6
210404	Ном, хэвлэл	1,795,700.00	274,100.00	1,521,600.00	15.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,724,100.00	29,174,505.00	1,549,595.00	95.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	185,576,500.00	171,464,102.36	14,112,397.64	92.4
2105	Нормативт зардал	833,141,000.00	658,771,073.61	174,369,926.39	79.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,186,000.00	13,962,170.67	3,223,829.33	81.2
210502	Хоол, хүнс	756,887,400.00	595,268,314.94	161,619,085.06	78.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,067,600.00	49,540,588.00	9,527,012.00	83.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	299,868,400.00	237,684,578.88	62,183,821.12	79.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	232,849,700.00	190,486,650.88	42,363,049.12	81.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	0.00	500,000.00	0.0
210604	Урсгал засвар	66,518,700.00	47,197,928.00	19,320,772.00	71.0
2107	Томилолт, зочны зардал	20,493,300.00	8,398,100.00	12,095,200.00	41.0
210702	Дотоод албан томилолт	15,015,700.00	8,398,100.00	6,617,600.00	55.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,477,600.00	0.00	5,477,600.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,871,198,200.00	1,379,486,019.78	491,712,180.22	73.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,595,639,600.00	1,136,175,197.98	459,464,402.02	71.2

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	143,851,800.00	143,198,700.00	653,100.00	99.5
210803	Даатгалын үйлчилгээ	56,860,800.00	53,702,753.00	3,158,047.00	94.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	12,338,800.00	6,497,840.00	5,840,960.00	52.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,206,600.00	2,108,576.00	3,098,024.00	40.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,380,300.00	21,202,486.00	3,177,814.00	87.0
210807	Газрын төлбөр	13,486,400.00	11,637,951.00	1,848,449.00	86.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,163,600.00	3,662,515.80	1,501,084.20	70.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,270,300.00	1,300,000.00	12,970,300.00	9.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,191,100.00	6,559,544.10	14,631,555.90	31.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,925,500.00	966,444.10	7,959,055.90	10.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,265,600.00	5,593,100.00	6,672,500.00	45.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	634,474,000.00	551,491,986.15	82,982,013.85	86.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	634,474,000.00	551,491,986.15	82,982,013.85	86.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	541,939,100.00	466,368,744.15	75,570,355.85	86.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,534,900.00	85,123,242.00	7,411,658.00	92.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	0!
220001	Барилга байгууламж	0.00	0.00	0.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00	0.00	0
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	0.00	0.00	0!
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,768,550,900.00	27,526,534,290.46	1,242,016,609.54	95.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,796,341,000.00	26,109,574,247.56	686,766,752.44	97.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	26,796,341,000.00	26,109,574,247.56	686,766,752.44	97.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,972,209,900.00	1,416,960,042.90	555,249,857.10	71.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	208,123,000.00	114,822,118.00	93,300,882.00	55.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,764,086,900.00	1,302,137,924.90	461,948,975.10	73.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	424,759.58	-424,759.58	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,320.00	3,142.00	178.00	94.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	34.00	34.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	34.00	34.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,643.00	1,554.00	89.00	94.6
620001	Удирдах ажилтан	35.00	34.00	1.00	97.1
620002	Гүйцэтгэх ажилтан	1,328.00	1,250.00	78.00	94.1
620003	Үйлчлэх ажилтан	280.00	270.00	10.00	96.4
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,816,901,175.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,816,901,175.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,345,084,422.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,783,639.96
210101	Үндсэн цалин	190,783,639.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,789,665.47
210201	Тэтгэврийн даатгал	21,789,665.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,399,190.00
210301	Гэрэл, цахилгаан	4,051,670.00
210302	Түлш, халаалт	9,347,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	311,381,303.99
210401	Бичиг хэрэг	161,706,265.46
210402	Тээвэр, шатахуун	70,787,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,098,181.03
210404	Ном, хэвлэл	604,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	427,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,758,477.50
2105	Нормативт зардал	16,880,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,837,000.00
210502	Хоол, хүнс	11,929,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	114,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,344,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,441,600.00
210602	Тавилга	4,601,800.00
210604	Урсгал засвар	8,301,200.00
2107	Томилолт, зочны зардал	26,106,843.00
210701	Гадаад албан томилолт	3,517,943.00
210702	Дотоод албан томилолт	22,588,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275,193,571.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,252,015,571.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,178,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	444,204,739.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,229,719.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,975,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,471,816,752.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,893,068,591.60
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	77,856,735,779.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,950,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,382,812.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	578,748,161.28
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	26,382,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	12,619,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг	539,746,661.28

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,816,901,175.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,816,901,175.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	42,884,324,841.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	866,296,132.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,013,848,598.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,052,431,603.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, НДШ-ийн тайланг үнэн зөв илэрхийлэх, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ, Г.Түвшинзаяа нар гүйцэтгэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/193 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны соёл төлөвшүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх

мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлж, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох.

- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшнийг бууруулах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.
- Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж ХХҮЕГ-ын даргын 2018 оны А/174 дүгээр тушаалаар баталж мөрдөж байгаа боловч холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлт болон Засгийн газар, Сангийн яамнаас шинээр гаргасан бодлого чиглэлтэй уялдуулж өөрчлөөгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газар нь 2020 онд ХХҮЕГ-ын болон харьяа аймаг, дүүргийн 6 ХХҮГ, хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаа, Халамжийн сан, ХЭДС-ийн төсвийн зарцуулалтад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, Баянзүрх дүүргийн ХХҮХ, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Говь-Алтай, Дорнод аймгийн ХХҮГ-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийж, 79.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 92.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж нийт 175 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 16.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 92.4 сая төгрөгийн албан шаардлага, 165 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан агентлагийн санхүүгийн үйл ажиллагаа болон Халамжийн сан, ХЭДС-ийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг Коронавируст халдвар /ковид-19/ -ын цар тахлын үеийн хөл хорионоос шалтгаалж хийгдээгүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг сонгосон суурь үзүүлэлт болох 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 112,398.5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 1,124.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 30.8 сая, эцсийн үлдэгдэл 39.5 сая төгрөг болж, 8.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	0.4	0.4	1%
Банканд байгаа бэлэн мөнгө	30.8	39.1	8.3	99%
Дүн	30.8	39.5	8.7	100%

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 0.4 сая төгрөг касст байгаа бэлэн мөнгө, 38.6 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.4 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянгол дүүргийн ХХҮХ нь анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 2.0 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн;

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 2,016.9 сая, эцсийн үлдэгдэл 910.3 сая төгрөг болж, 1,106.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай хологдсон авлага	9.3	11.3	2.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	5.7	4.1	-1.6
Татаас, санхүүжилтийн авлага	1,553.7	460.3	-1,093.4
Бусад авлага	448.2	434.6	-13.6
Байгууллагаас авах авлага	157.8	144.5	-13.3
Хувь хүнээс авах авлага	290.3	290.1	-0.2
Дүн	2,016.9	910.3	-1,106.6

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай олон улсын байгууллага, гадаадын байгууллагад ажиллаж байсан Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс үүссэн 7.7 сая төгрөгийн Сангийн яамнаас авах авлага байна.

Аудитын илрүүлэлт

- ХХҮЕГ нь төсвийг зохистой удирдаагүйгээс санхүүгийн тайланд 4.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Дундговь аймгийн ХХҮГ 2.7 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг данс буруу бүртгэж өглөгийн дансанд бүртгэж тайлагнасан;
- Ховд аймгийн ХХҮГ өмнөх оноос шилжин ирсэн 4.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эцсийн үлдэгдэл 9.0 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	9.0	9.0
Дүн	-	9.0	9.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Дорноговь аймгийн ХХҮГ, Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн урьдчилж төлсөн төлбөр бүртгэлтэй байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,247.5 сая, эцсийн үлдэгдэл 1,394.9 сая төгрөг болж, 147.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	47.0	43.4	-3.6
Тусгай зориулалттай материал	44.0	39.7	-4.3
Эм боох материал	3.0	3.7	0.7
Хангамжийн материал	1152.7	1309.5	156.8
Бичиг хэргийн материал	81.9	91.3	9.4
Аж ахуйн материал	545.0	589.9	44.9
Сэлбэг хэрэгсэл	50.3	58.5	8.2
Түлш, шатах тослох материал	53.6	61.5	7.9
Барилгын засварын материал	7.4	7.7	0.3
Хүнсний материал	26.7	19.3	-7.3
Бусад хангамжийн материал	388.0	481.4	93.4
Бэлэн бүтээгдэхүүн	20.5	21.0	0.4
Мал амьтад	27.3	21.0	-6.3
Дүн	1,247.5	1,394.9	147.4

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар орлого, зарлагыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн/ Багануур дүүргийн ХХҮХ 4.3 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮХ 3.3 сая/
- Бараа материалын худалдан авалтын дүн цахим и- баримтын системийн дүнгээс зөрүүтэй болон бэлтгэн нийлүүлэгчээс анхан шатны баримтад цахим и-баримтыг бүрдүүлээгүй/ Сүхбаатар дүүргийн ХХҮХ 4.2 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 6.2 сая төгрөг/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 35,158.5 сая, эцсийн үлдэгдэл 45,756.0 сая төгрөг болж, 10,597.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	29,857.8	39,896.7	10,038.9
Барилга, байгууламж, орон сууц	25,699.4	33,523.3	7,823.9
Авто-тээврийн хэрэгсэл	526.7	262.0	264.7
Машин тоног			
төхөөрөмж(компьютер)	1,895.0	4,053.7	2,158.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,377.8	1,499.6	121.8
Бусад үндсэн хөрөнгө	346.5	555.2	208.7
Дуусаагүй барилга, байгууламж	9.5	-	-9.5

Ном	2.9	2.9	-
Биет бус хөрөнгө	5,300.7	5,859.3	558.6
Програм хангамж	932.0	1,423.7	491.7
Бусад биет бус хөрөнгө	4,368.7	4,435.6	66.9
Дүн	35,158.5	45,756.0	10,597.5

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 177.0 сая, хандиваар 3,832.3 сая, шилжүүлэн авсан 7,207.7 сая, бусад эх үүсвэрээр 3,198.6 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 82.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 1,268.5 сая, акталсан 1,681.5 сая, бусад 58.4 сая, дахин үнэлгээний хорогдол 357.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянзүрх дүүргийн ХХҮХ нь санхүүгийн тайланд 2.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тусгасан;
- Үндсэн хөрөнгийн дансанд биетээр оршин байхгүй хөрөнгө бүртгэлтэй байна. /Налайх дүүргийн ХХҮХ 19.4 сая, Сонгино хайрхан дүүргийн ХХҮХ 1.1 сая/;
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй /Дархан аймгийн ХХҮГ 22.3 сая, Баянгол дүүргийн ХХҮХ 137 нэр төрлийн, Сүхбаатар дүүргийн ХХҮХ 139.7 сая, Хан-Уул дүүргийн ХХҮХ 2.4 сая /;
- Дундговь аймгийн ХХҮГ нь худалдан авсан 0.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6.4 сая, эцсийн үлдэгдэл 12.6 сая төгрөг болж, 6.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	0.8	6.3	5.5	89.1%
Байгууллагад төлөх өглөг	5.6	5.7	0.1	1.0%
Хувь хүмүүст төлөх өглөг	-	0.6	0.6	9.9%
Нийт дүн	6.4	12.6	6.2	100.0%

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 12.6 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон, байгууллагад төлөх, хувь хүмүүст төлөх өр байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөговь аймгийн ХХҮГ төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 3.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Сүхбаатар дүүргийн ХХҮХ-ын санхүүгийн тайлангаарх ХХОАТ-ын өглөг, татварын тайлангаарх өглөгийн үлдэгдэл 7.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан;

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 38,447.3 сая, эцсийн үлдэгдэл 48,097.1 сая төгрөг болж, 9,649.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,418.4	14,585.8	167.4	1.7%
Хуримтлагдсан үр дүн	17,679.3	27,379.3	9,700.0	100.5%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,349.6	6,132.0	-217.6	-2.2%
Дүн	38,447.3	48,097.1	9,649.8	100.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 14,585.8 сая төгрөг болж 167.4 сая төгрөгөөр өссөн нь Говь-алтай аймгийн ХХҮГ, Хэнтий аймгийн ХХҮГ, Хөвсгөл аймгийн ХХҮГ-ууд нь эзэмших эрхтэй газрыг үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 6,132.0 сая төгрөг болж 217.6 сая төгрөгөөр буурсан нь харьяа газрууд акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хасаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 27,379.3 сая төгрөг болж 9,700.0 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан барилга байгууламж болон Хүнс тэжээл нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төслийн хүрээнд бэлтгэгдсэн машин тоног, төхөөрөмж хүлээн авсныг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 234.8 сая төгрөг бүртгэж өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн нь Хөвсгөл, Булган аймгийн ХХҮГ-ууд 2011, 2016 онд үүссэн 7.2 сая төгрөгийн авлагыг данснаас хасаж бүртгэсэн, Налайх дүүргийн ХХҮХ, Дорнод, Дундговь, Төв аймгийн ХХҮГ-ын тайланд нийт 242.0 сая төгрөгийн залруулах бичилт хийгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

УИХ-ын 2020 оны төсөв батлах тухай тогтоолд зааснаар ажлын байрны хураамжийн орлогоос 800.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 323.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 40.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ажлын байрны хураамжийн орлого	800.0	323.5	476.5	40.4
Нийт дүн	800.0	323.5	476.5	40.4

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 476.5 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар /ковид-19 /-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хилээр орох, гарах хөдөлгөөнийг хаасантай холбоотойгоор хөдөлмөр эрхлэх визээр ирэх гадаад иргэдийн тоо буурснаас шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 32,737.4 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,136.0 сая төгрөгөөр бууруулж 29,601.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардлыг 1,254.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 888.8 сая, бусад бараа, ажил, үйлчилгээний зардлыг 710.8 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 282.2 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны тодотгосон төсвөөр төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зориулан 28,768.5 сая төгрөгийн төсвийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 26,796.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 208.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,764.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 26,722.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төлөвлөснөөс 73.4 сая төгрөгөөр санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 114.8 сая төгрөгөөр бүрдүүлж, батлагдсан төсвөөс 93.3 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын улмаас хил хаагдаж хөдөлмөр эрхлэх визээр орж ирэх гадаад иргэдийн тоо буурснаас үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого дутуу бүрдэх гол шалтгаан болсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 1,302.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 461.9 сая төгрөгөөр тасарсан цар тахлын улмаас ЗГ, УОК-ын шийдвэрээр ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг зогсоосноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 27,478.0 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цар тахлын улмаас газар, хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг ахмадын амралт, сувиллын үйл ажиллагаа зогсоосонтой холбоотой үндсэн үйл ажиллагаанаас санхүүждэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн, туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл дутуу биелсэнтэй холбоотойгоор урсгал зардлын эрхийг хязгаарлаж зайлшгүй шаардлагатай зардлуудыг санхүүжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 57.1 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 42,827.2 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 866.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,013.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35,052.4 сая, нийт 80,816.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 2,345.1 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 36.3 сая, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж буюу хүүхдийн мөнгөнд 74,921.2 сая, хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх зардалд 2,935.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 578.7 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, үүнээс 460.3 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын арга хэмжээ, бүлэг хооронд 49.4 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан /Баянгол дүүргийн ХХҮХ 2.9 сая, Баянзүрх дүүргийн ХХҮХ 1.0 сая, Налайх дүүргийн ХХҮХ 3.8 сая, Төв аймгийн ХХҮГ 6.0 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 1.1 сая/;
- Баянгол дүүргийн ХХҮХ нь 1.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг давхардуулан олгосон, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ нь 1.2 сая төгрөгийн хоол унааны хөнгөлөлтийг ажилтнуудад дутуу олгосон, Говь-Алтай аймгийн ХХҮГ сахилгын шийтгэлтэй ажилтанд 1.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ХХҮЕГ нь Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 148 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 20 мэдээллийг хугацаа хоцроож, 483.0 сая төгрөгийн 5 төрлийн мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал:

- Байгууллагын дараа жилийн төсвийн төсөл;
- Хагас жилийн санхүүгийн тайлан;
- Худалдан авах ажиллагааны тайлан;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн 10 төрлийн 170.0 сая төгрөгийн;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 гүйлгээний 313.0 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 170.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 218.9 сая төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
							Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	170.3	2	170.3	0	0	100.0
Зөвлөмж	6	218.9	4	190.0	2	28.9	66.7
Нийт	8	389.2	6	360.3	2	28.9	75.0

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд;

- Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу олгосон нөхөн төлбөрийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх.
- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж агентлагийн дарга, дэд дарга нарын хот доторх ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн багтаамж багатай автомашин хэрэглэж байх.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 төсвийн байгууллага, 2 ахмадын сан нийт 36 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 28 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 төсвийн байгууллага, 2 ахмадын сан түүврээр хамрагдсан, 3 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 25, “Хязгаарлалттай” 3 /Баян-Өлгийн аймгийн ХХҮГ, Сүхбаатар, Налайх дүүргийн ХХҮХ/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,850.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 511.3 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 10.7 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 718.0 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 610.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 56 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд ХХҮЕГ нь 192.3 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд бүртгэж буруу тайлагнасныг залруулав.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын арга хэмжээ, бүлэг хооронд буюу үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 8.2 сая төгрөгийг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ болон байр ашиглалтын арга хэмжээний зардалд 26.4 сая төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “.... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

2. Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан ажиллагааны тайлан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 170.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 гүйлгээний 313.0 сая төгрөгийг мэдээлээгүй;

Мөн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийн 1-6,9,10-р сарыг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийн 3,8,9,11-р сарыг, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 1,3,5,6,8,9,10 сарын мэдээллүүдийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ,

нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.7-д “байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх гэж батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3. 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 3.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2 -т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

Төвлөрүүлэн захирагчид 11.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,125.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 319.0 сая төгрөгийн 21 алдааг аудитын явцад залруулж, 7.3 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 200.4 сая төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 599.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 51 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ХХҮЕГ-ын харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарах татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- ХХҮЕГ-ын санхүүгийн тайланд өмнөх оноос шилжин ирсэн байгууллагаас авах 7.7 сая төгрөгийн авлага, байгууллагад төлөх 4.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй;
- ХХҮЕГ-ын Хяналт мониторингийн газрын жилийн ажлын төлөвлөгөөнд 4 дүгээр сард ХХҮЕГ болон ХЭДС, Халамжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн боловч Ковид 19 цар тахлын үеийн нөхцөл байдлаас гэсэн шалтгаанаар тайлант жилд багтаан хяналт шалгалтыг хийгээгүй;
- Агентлагийн дарга, дэд дарга нарын хотын доторх албан ажлын хэрэгцээнд 4500 см3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж бүхий Toyota Land cruiser 200 маркийн 2 автомашин хэрэглэж байгаа нь суудлын автомашин ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-дахь заалт, тогтоолын хавсралтаар баталсан албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалттай нийцэхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.

4.1.1 Илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ-ын 4.7 сая төгрөгийн, НДШ-ийн 0.2 сая төгрөгийн нийт 4.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 2021 оны 2 дугаар улиралд багтаан дээрх авлага, өр төлбөрийг барагдуулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нийслэлийн татварын алба болон ХУД-ын НДХ-тэй хоорондын тооцоог нийлж, жилийн эцсийн тайлангаар 4.8 сая төгрөгийн авлагыг бүртгэсэн ба 2021 онд уг авлагыг суутган тооцож, цаашид байгууллага хоорондын тооцоог сар тутам хийж, зөрчлийг арилгаж ажиллах болно.

4.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

НДШ-ийн тайланд 1 ажилтны тооцсон цалинг 0.2 сая төгрөгөөр илүү, 4 ажилтны тооцсон цалинг 6.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заасантай нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх, НДШ-ийн торгууль, алдангийн өр үүсэх.

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, НДШ-ийн тайланд цалин түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлж байх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цалингийн нэгдсэн системийг 2020 оны 08 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн ба уг программ нь НДШ-ийн тайланг татахдаа цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс зөрүүтэй татсан алдаа гарсныг аудитын явцад залруулгыг хийсэн. Цаашид программын алдаагүй хэвийн ажиллуулахад Сангийн яамтай хамтран ажиллаж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана.

4.3 Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

ХХҮЕГ-ын биет бус хөрөнгийн дансанд цаашид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй болсон 7 төрлийн 792.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 -д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Ашиглах боломжгүй болсон хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байх, дансны ангилал буруу бүртгэсэн байх.

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид ашиглах боломжгүй болсон программ хангамжийг данс бүртгэлээс хасах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж ашиглагдахгүй байгаа биет бус хөрөнгө, программ хангамжийг Мэдээлэл технологийн хэлтэстэй хамтарч шийдвэр гарган актлах саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллана.

4.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл.

4.4.1 Илрүүлэлт:

ХХҮЕГ-ын үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 964 нэр төрлийн 3,700.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтыг газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалт, УСНББОУС17-ийн 44-т “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

4.4.2 Эрсдэл:

Үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хөрөнгийн үнэ цэнэ буурах.

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээ бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон ч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, харин ашиглах боломжгүй хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж данс бүртгэлээс хасах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Элэгдлээр анхны өртгөө бүрэн нөхсөн, хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоосон ба уг саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/16/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар					
1	Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ-ын 4.7 сая төгрөгийн , НДШ-ийн 0.2 сая төгрөгийн зэрэг, нийт 4.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн.	4.9	Зөвлөмж	Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч	Д.Билэгмаа, М.Мэндбаяр
2	Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын арга хэмжээ, бүлэг хооронд буюу үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 8.2 сая төгрөгийг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ болон байр ашиглалтын арга хэмжээний зардалд 26.4 сая төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан.	34.6	Албан шаардлага		
3	НДШ-ийн тайланд 1 ажилтны тооцсон цалинг 0.2 сая төгрөгөөр илүү, 4 ажилтны тооцсон цалинг 6.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	6.3	Зөвлөмж		
4	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, худалдан авах ажиллагааны тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн 10 төрлийн 170.0 сая төгрөгийн, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 32 гүйлгээний 313.0 сая төгрөгийн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулаагүй, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийн 1,2,3,4,5,6,8,9,10-р сарыг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийн 3,8,9,11-р сарыг, байгууллагын батлагдсан орон тоонд	483.0	Албан шаардлага	ХХҮЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ^Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч, ^санхүүгийн тайлангийн нэгтгэл, үндсэн хөрөнгө хариуцсан ахлах мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл, Д.Билэгмаа, М.Мэндбаяр, Г.Оюун

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

	орсон өөрчлөлтийн 1,3,5,6,8,9,10 сарын мэдээллүүдийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.				
5	Агентлагийн дарга, дэд дарга нарын хотын доторх албан ажлын хэрэгцээнд 4500 см3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж бүхий Toyota Land cruiser 200 маркийн 2 автомашин нь суудлын автомашин ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" тогтоолын хавсралтаар баталсан Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалттай тус тус нийцэхгүй байна.	-	Албан шаардлага	Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, санхүүгийн тайлангийн нэгтгэл, үндсэн хөрөнгө хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Билэгмаа, Г.Оюун
6	Биет бус хөрөнгө дансанд цаашид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй болсон 7 төрлийн 792.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.		Зөвлөмж		
7	2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын үлдэгдэл 3.4 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	3.4	Төлбөрийн акт тогтоосон	Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч	Д.Билэгмаа, М.Мэндбаяр
Баянгол дүүргийн ХХҮХ					
8	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүй, санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 137 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	М.Насанжаргал
9	Хүчин төгөлдөр анхан шатны баримт буюу цахим төлбөрийн баримтаар нотлогдохгүй зардлын гүйлгээ гарсан.	2.0	Зөвлөмж		
10	Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа мэдээллээ оруулаагүй.		Зөвлөмж		
11	Нийт цалингийн зардал 2.9 сая төгрөгөөр хэтэрсэн, хэтрэлтийг ЭМНДШ-ийн зардалд бүртгэсэн, 1.6 сая төгрөгийн урамшууллын зардлыг давхардуулан олгосон.	4.5	Зөвлөмж		
Баянзүрх дүүргийн ХХҮХ					
12	Жолоочийн шатахуун зарцуулалтыг нормативын дагуу тооцоогүй	0.2	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Нягтлан бодогч	Л.Цолмонгэрэл, Б.Баттуяа

13	Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү тооцож шилжүүлсэн.	0.4	Зөвлөмж		
14	Хөрөнгийн бүртгэлд ашиглагдаж хөрөнгө бүртгэлд тусгагдаагүй.	2.0	Зөвлөмж		
15	Аудитын түүвэр хийхэд 0.4 сая төгрөгийн шатахууны зардлыг бусад бараа үйлчилгээний зардлаас 0.6 сая төгрөгийн шагнал урамшууллыг цалингийн зардлаас санхүүжүүлж, зардлын ангиллыг буруу тайлагнасан.	1.0	Зөвлөмж		
Багануур дүүргийн ХХҮХ					
16	НББ-н бодлогын баримт бичигт хууль эрх зүйн актын өөрчлөлт, сайжруулалт хийгдээгүй байна.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ш.Зулзаяа
17	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4.3 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан.	4.3	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ш.Зулзаяа
18	Цалингаас ХХОАТ-ыг суутгахдаа хөнгөлөлтийн шатлалыг буруу зөрүүтэй тооцсон, 1 ажилтнаас ххоат суутгаагүй	0.2	Төлбөрийн акт тогтоосон	Нягтлан бодогч	Ш.Зулзаяа
Багахангай дүүргийн ХХҮХ					
19	Тайлант хугацаанд оруулбал зохих 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцруулан байршуулсан байна.	0.1	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Болорцэцэг
Налайх дүүргийн ХХҮХ					
20	Тайлант хугацааны 42.2 сая төгрөгийн худалдан авалтын И- баримт системд бүртгэгдээгүй.	42.2	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
21	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, нэр тодорхойгүй 19.4 сая төгрөгийн 3 төрлийн хөрөнгө бодитоор оршино байхгүй байна.	19.4	Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
22	Шилэн дансны цахим хуудсанд 15 мэдээллийг хугацаа хоцроосон, 14 мэдээллийг байршуулаагүй байна.		Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
23	Хэлтсийн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа машин нь татан буугдсан Налайх дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтсийн нэр дээр бүртгэлтэй байна.		Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
24	Үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан ч, орлуулан ашиглах хөрөнгө байхгүй тул ашиглаж байгааг дахин үнэлж, эсвэл үнэ бууруулж бүртгэх цаашид хэрхэх талаар өмч хамгаалах комиссын шийдвэр гаргаагүй байна.		Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
25	Цалингийн зардлаас 3.8 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал руу гүйлгэж тайлагнасан.	3.8	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Х.Лхагвасүрэн
Нийслэлийн ХХҮГ					

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

26	Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн шалгасан ажилтны гарын үсэг тамга тэмдэг бүрэн баталгаажуулаагүй.		Зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхбаяр, Н.Энхтуяа
27	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,732.1 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй.	-	Албан шаардлага	Дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхбаяр, Н.Энхтуяа
28	Тайлант хугацаанд цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлсэн/ худалдан авалтанд Е-баримт аваагүй/		Зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхбаяр, Н.Энхтуяа
Сүхбаатар дүүргийн ХХҮХ					
29	Гэрээт 2 байгууллагаас бараа материал худалдан авсны үнэнд харилцах данснаас 13.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Үүнээс 4.2 сая төгрөгийн бараа материал И баримтаар нотлогдохгүй байна.	4.2	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа байгууллагуудын үйл ажиллагааны бүтцэд 2016 онд өөрчлөлт орж Халамжийн болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангууд нэгдэхэд орон нутгийн өмч буюу нийт 323 ширхэг 231.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 200.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 31.1 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг төрийн өмч рүү шилжүүлэх арга хэмжээ авагдаагүйгээс өмч эзэмших гэрээ байхгүй байна. Үүнээс шалтгаалан төрийн өмчийн программ ашиглалтгүй, төрийн өмчийн тайлан гаргаагүй байна.	31.1	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
31	Байгууллагын дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 198 ширхэг 139.7 сая төгрөгийн үндсэн болон биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.	139.7	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
32	Биет хөрөнгүүдэд бүртгэлийн код хийгдээгүй.	79.4	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
33	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингаас ХХОАТ илүү суутгасан .	0.8	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
34	Санхүүгийн тайлангаар ХХОАТ-ын өглөггүй тайлагнагдсан боловч татварын цахим системд 7.3 сая төгрөгийн өглөг бүртгэгдсэн. Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	7.3	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн
35	Шилэн дансанд бүтэн жилээр байршуулах 10 мэдээллээс хугацаандаа 8, хугацаа хоцроосон 1, байршуулах хугацаа болоогүй 1, хагас жилээр байршуулах 3 мэдээллээс	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Цэвэлсүрэн

	хугацаандаа байршуулсан 3 мэдээлэл, улирал бүр байршуулах 4 мэдээллээс хугацаандаа 4, сар бүр байршуулах 24 мэдээллээс хугацаандаа 23, хугацаа хоцроосон 1, тухай бүр байршуулах 127 мэдээллээс хугацаандаа 82, хугацаа хоцроосон 20, хугацаандаа байршуулаагүй 25 мэдээлэл байна. Нийт 167 мэдээлэл байршуулахаас хугацаандаа байршуулсан 120, хугацаа хоцроож байршуулсан 22, мэдээллийг байршуулаагүй 25, мэдээллийн хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.				
Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ					
36	Шийтгэлтэй хүнд урамшуулал олгосон. Үндсэн цалингаас тооцож нэмэгдэл олгосон	0.9	Төлбөрийн акт тогтоосон	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
37	Худалдан авалт Е баримтаар баталгаажуулж		Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
38	Гадны байгууллагуудын хэрэглээг дотроо давхар тоолуурын тооцоо хийдэг гэх боловч сар бүр тоолуурын бичилтийг баталгаажуулж, нэхэмжилсэн баримт байхгүй байна.	-	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
39	Нийслэлийн өмчийн газрын 3 програм бодитоор байхгүй.	1.1	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
40	2- р сард хоол унааны мөнгө дутуу олгосон	1.2	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
41	Хяналт , шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд 2020 онд хэлтсийн хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй.		Зөвлөмж	Дарга	Э.Энхтуул
42	Шилэн дансны мэдээлэл дутуу оруулсан.		Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч	Н.Насанжаргал
Хан-Уул дүүргийн ХХҮХ					
43	Тус байгууллагын баланст ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа 107 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна. Мөн 2010 онд худалдан авсан 8 нэрийн 5.5 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 2.4 сая төгрөгөөр илүү байгуулж үлдэх өртөггүй болгосон.	2.4	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Б.Бадамсүрэн М.Батцэцэг
44	Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа оруулсан мэдээллийн мөнгөн дүн дутуу, 12 дугаар сарын мэдээллийг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Б.Бадамсүрэн М.Батцэцэг
Булган аймгийн ХХҮХ					
45	Тайлант хугацаанд 0.3 сая төгрөгийн авлага үлдэгдэлтэй.	0.3	Зөвлөмж	Нягтлан бодогч	О.Баярчимэг
46	Цалингийн зардлаас 1.2 сая төгрөгийг ахмадын санд шилжүүлсэн	1.2	Зөвлөмж	Нягтлан бодогч	О.Баярчимэг

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

47	НИК ххк-тай байгуулсан гэрээний дагуу 3 хувийн хөнгөлөлт эдлээгүй авлага үүсгээгүй байна	0.1	Зөвлөмж	Нягтлан бодогч	О.Баярчимэг
48	Бараа материал дээр байгаа хөрөнгийн чанартай бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэх	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	О.Баярчимэг
49	Үр дүнгийн урамшуулал илүү олгосон	0.4	Төлбөрийн акт тогтоосон	Нягтлан бодогч	О.Баярчимэг
50	Шилэн дансанд 10 тушаалыг тавиагүй байна. Энэ нь данда ажлаас чөлөөлөгдсөн болон гэрээт ажилчдын тушаал байсан.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	О.Баярчимэг
Баян-Өлгий аймгийн ХХҮХ					
51	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах	30.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Ж.Мухибат
52	Шилэн дансаны 46 мэдээлэлийг жилийн турш хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бичиг хэрэг, шатахуун, БҮТЭЗҮйлсийг орлогод аваагүй шууд зардалдлагаар гаргасан	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ж.Мухибат
53	Байгууллагын 3 хүнтэй холбоотой илүү олгосон цалинг хуулийн хугацаанд нь 1579,0 төгрөгийг ажилчидаас суутгаж тухайн дансанд шилжүүлэх	1.6	Төлбөрийн акт тогтоосон	Нягтлан бодогч	Ж.Мухибат
Говь-Алтай аймгийн ХХҮХ					
54	Цалин бодохдоо хоногийн зөрүү гаргаснаас 0.3 сая төгрөгийн хоолны мөнгө илүү олгосон.	0.3	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
55	Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 0.2 сая төгрөгийн унааны зардлыг тээвэр шатахууны зардлаас гаргасан.	0.2	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
56	Төсвийн захирагч сахилгын шийтгэлтэй байхад улирлын ажлын үзүүлэлтээр 1.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.	1.1	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
57	Шүүхийн шийдвэрээр олгосон 7.4 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.	7.4	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
58	Тайлант хугацаанд оруулбал зохих 84 мэдээллээс хугацаандаа оруулсан 77 мэдээлэл, хагцацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.		Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
Говьсүмбэр аймгийн ХХҮХ					
59	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 3 тушаал шийдвэрийг дутуу оруулсан.	-	Албан шаардлага	Нягтлан бодогч	Аззаяа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

60	Цахим татварын системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж хяналт тавьж ажиллаагүйгээс 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Аззаяа
Дархан-уул аймгийн ХХҮХ					
61	Дансны үнэ тэглэсэн 22.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.	22.4	Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Саруул
62	Төсвийн төсөөллийг бодитой төлөвлөөгүй.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Саруул
63	Ээлжийн амралтаараа БНСУ яваад гацсан мэргэжилтэнд 2 сарын цалингийн 50 хувь болох 0.6 сая, ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэлийг ажил олгогчийн захиалгаар суралцагч кодоор 4 сарын 0.2 сая төгрөгийг байгууллагаас төлсөн.	0.8	Төлбөрийн акт тогтоосон	Нягтлан бодогч	Н.Саруул
64	Батлагдсан төсвөөс 0.5 сая төгрөгийн шатахуун нөөцөлсөн.	0.5	Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Саруул
65	Тооллогын дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулаагүй.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Саруул
66	Шилэнд дансанп 16 тушаалыг огт мэдээлээгүй.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Саруул
Дорнод аймгийн ХХҮХ					
67	Төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалтыг зөрчсөн.Тайлант оны эцэст хүнс , түлш, шатах тослох материал нөөцөлсөн.	1.8	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Х.Сарандагина
68	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн 18 дугаар зүйлийн 18.1.1 зааснаар татварын хөнгөлөлт чөлөөлтөнд хамруулах гэсэн заалтыг зөрчсөн.	1.4	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Х.Сарандагина
69	Ахмад настны ХБИ-ийн амралт сувилалын үйл ажиллагаа ковид-19 цар тахалтай холбоотой 12 сараас үйл ажиллагаа нь зогссоны улмаас орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3.4 сая төгрөгөөр тасарсан .	3.4	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Н.Мөнхгэрэл, Х.Сарандагина
70	Шилэн дансанд 16 мэдээлэл хоцроон байршуулсан.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Х.Сарандагина
Дорноговь аймгийн ХХҮХ					
71	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ баримт аваагүй /Е баримтын бүрдэл ханган ажиллаагүй./	6.2	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Ганчимэг
Дундговь аймгийн ХХҮХ					
72	Албан хаагчдад олгосон цалингийн урьдчилгааг өглөг дансанд бичилт хийсэн.	2.7	Албан шаардлага	Нягтлан бодогч	Л.Буян-Эрдэнэ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.

73	Багаж, техник хэрэгслээс худалдан авсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	0.7	Албан шаардлага	Нягтлан бодогч	Л.Буян-Эрдэнэ
Сэлэнгэ аймгийн ХХҮХ					
74	Няравын бараа материалын тайланд жолоочийн тооцооны хуудас үйлдээгүй, шаардах хуудас хөтлөөгүй анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээг бүртгэсэн.	3.3	Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч	Б.Идэрчулуун
75	НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 0.4 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээний НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны цалингийн зардалд 1 сая төгрөг зэрэг нийт 1.4 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл аваагүй, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.	1.4	Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч	Б.Идэрчулуун
76	Шилэн дансны 49 мэдээлэл хоцроож байршуулсан, 3 6 9 11 мэдээг өмнөх сараар байршуулсан, мөн ашиг сонирхолын зөрчилгүй мэдээллийг байршуулаагүй.	-	Зөвлөмж	Ахлах нягтлан бодогч	Б.Идэрчулуун
Төв аймгийн ХХҮХ					
77	Шилэн дансны 19 мэдээлэл хоцроож байршуулсан, 3 6 9 11 мэдээг өмнөх сараар байршуулсан, мөн ашиг сонирхолын зөрчилгүй мэдээллийг байршуулаагүй	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Ууганбаатар
78	Хувь хүнээс бараа үйлчилгээг худалдан авахдаа татварын Е баримтаар баталгаажуулаагүй байна	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Ууганбаатар
79	Ахмадын хүндэтгэлийн зардал, хүүхдийн баярын бэлэгний зардалыг БГАҮТЗардлаас гаргасан.	6.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Н.Ууганбаатар
Увс аймгийн ХХҮХ					
80	Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаандаа байршуулаагүй байна.	60.6	Зөвлөмж	Дарга	Д.Цогт-Очир
Ховд аймгийн ХХҮХ					
81	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийх гэрээнд холбогдох заалтын нарийн тусгаагүй, жолоочийн засын тооцооны хуудсанд хөдөө сумдад ажилласанаар тооцсон ч цагийн бүртгэлд нарийвчлан бүртгээгүй зөрчил байна.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Х.Цэцэгбал
82	Өмнөх онуудад үүссэн 4077.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	4.1	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Х.Цэцэгбал
Хэнтий аймгийн ХХҮХ					

83	Шилэн дансны цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт нийт 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	С.Эрдэнэжаргал, Д.Зоригтбаярмаа
Хөвсгөл аймгийн ХХҮХ					
84	Шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 129 мэдээлэл оруулсан 20 мэдээлэл оруулаагүй		Зөвлөмж	Нягтлан бодогч	Эрдэнэбат
85	Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 123.7 сая төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 866.6 сая төгрөгөөр батласан ба 8.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Эрдэнэбат
86	Туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөсөн хэмжээнээс 172.4 сая мянгаар төгрөгөөр тасалсан	172.4	Зөвлөмж	Нягтлан бодогч	Эрдэнэбат
Өвөрхангай аймгийн ХХҮХ					
87	Аудитын тулгалтаар 6.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр ирсэн орлогыг шилэн дансанд байршуулаагүй, 117.6 сая төгрөгийн хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй.	124.3	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Баяртогтох
Өмнөговь аймгийн ХХҮХ					
88	Шилэн дансны цахим сайтад 11 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Соёлмаа
89	Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын өр үүсгэсэн байна.	3.8	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Соёлмаа
Нийт дүн		1,338.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 25

№ 101 /АДН0065

Улаанбаатар хот

САГ-2021/16/СТА-ТБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

- 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 3,409,325 (Гурван сая дөрвөн зуун есөн мянга гурван зуун хорин тав) төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2 -т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 3,409,325 (Гурван сая дөрвөн зуун есөн мянга гурван зуун хорин тав) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Санхүү, төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа, ахлах нягтлан бодогч Б.Оюунбилэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

С.БАТ-ЭРДЭНЭ
Г.ТҮВШИНЗАЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Akt\2021\0325auditiin 2-R Gazar6.Docx

001090139



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 442/А0170065

Улаанбаатар хот

САГ - 2021/16/СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн арга хэмжээ хооронд буюу үндсэн үйл ажиллагааны зардлаас гэрээгээр гүйцэтгүүлэх, байр ашиглалтын арга хэмжээний зардалд 34,607,535 (Гучин дөрвөн сая зургаан зуун долоон мянга таван зуун гучин таван) төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох журам, зааврыг зөрчиж, Төсвийн эдийн засгийн ангиллыг арга хэмжээ хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Санхүү, төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа, төсвийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн М.Мэндбаяр нарт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
С.БАТ-ЭРДЭНЭ
Г.ТҮВШИНЗАЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, I-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R Газар\49.Docx

80818



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 443/АДН0065

Улаанбаатар хот

САГ-2021/16/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан ажиллагааны тайлан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 170,026,946 (Нэг зуун далан найман сая хорин зургаан мянга есөн зуун дөчин найм) төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32 гүйлгээний 312,952,462 (Гурван зуун арван хоёр сая есөн зуун тавин хоёр мянга дөрвөн зуун жаран хоёр) төгрөгийг мэдээлээгүй;

Мөн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийн 1-6,9,10-р сарыг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийн 3,8,9,11-р сарыг, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 1,3,5,6,8,9,10 сарын мэдээллүүдийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0325auditin 2-R Gazar50.Docx

00180822

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Билэгмаа, төсвийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн М.Мэндбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Я.САМБУУНЯМ

С.БАТ-ЭРДЭНЭ

Г.ТҮВШИНЗАЯА

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.